

Аудит хийх үндэслэл: Улсын Их Хурлын Төсвийн Байнгийн хорооны 2016 оны 01 дүгээр тогтоол, Үндэсний аудитын газрын харьяа Төв аймгийн аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсны дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн дагуу хийв

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хууль тогтоомжийн дагуу төлөвлөгдсөн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулжээ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт



АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	
Үндэсний аудитын газрын харьяа Төв аймгийн аудитын газар	
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	
Аудитын менежер О.Амаржаргал	
Ахлах аудитор Ц.Базарсад	
Аудитор Ж.Бямбацогт	
Шинжээч Ц.Хишигжаргал	
2016 оны 10 дугаар сарын 05-ны өдөр	
Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар 70272582, 70272463 дугаарын утас, 70272248 дугаарын факсаар харилцана уу	
ХАЯГ: Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	
	Товчилсон үгсийн тайлбар 3
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4
	Асуудал 1
	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтийг бодитой дүгнэхгүй байна 6
	Асуудал 2
	Хүн амын ундны болон ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөөгүй байна. 17
	Асуудал 3
	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хууль тогтоомжийн дагуу төлөвлөгдсөн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулжээ 26
	Асуудал 4
	Байгаль орчныг хамгаалах, орлого төвлөрүүлэх, нөхөн сэргээх арга хэмжээнд дотоод хяналтын ажил хийгдээгүй байна. 31
	Дүгнэлт 34
	Зөвлөмж 35
	Холбогдох байгууллагын санал:
	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал 36

Товчилсон үгийн тайлбар

МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭАХН	Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
БОНХЯ	Байгаль орчин ногоон хөгжлийн яам
БОНХАЖЯ	Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
БОХ	Байгаль орчны хяналт
ХХТХГ	Хан Хэнтийн тусгай хамгаалалтын газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**Аудит хийсэн үндэслэл**

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгийн хорооны 2016 оны 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2016 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт , хамарсан хүрээ

Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, аймаг, нийслэлийн хэмжээнд мөрдөх шийдвэр, дүрэм, журам батлаж биелэлтийг хангуулах үйл ажиллагаа нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд нийцлийн аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, сумын ИТХ, Засаг дарга нь байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан бүрэн үүргийг биелүүлсэн эсэх
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлөвлөж бүрэн төвлөрүүлсэн эсэх
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан эсэх
- Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хийх дотоод хяналт хуульд заасны дагуу хэрэгжүүлсэн эсэх

Аудитад аймгийн БОАЖГазар, аймаг, сумын ИТХ, бүх шатны Засаг даргын Тамгын газар, Санхүү төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлогын хэлтэс, холбогдох ажилтнууд, Татварын хэлтэс, сумдын байцаагчид, холбогдох аж ахуйн нэгжүүдийг хамруулан тэдгээрийн ажлын тайлан, статистик мэдээ, судалгааны материалууд аймгийн ИТХ-аас батласан төлөвлөгөө, аймгийн Засаг даргатай хийсэн гэрээний хэрэгжилтийн хүрээнд хийж гүйцэтгэсэн.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, АДБОУС 4100, гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Ойн тухай хууль
- Байгалийн ургамлын тухай хууль
- Ан амьтны тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”
- Засгийн газрын 2006 оны 137 дугаар тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагад байгаль орчны мэргэжлийн байгууллагын эрх олгох журам”
- Холбогдох бусад хууль, тогтоомж, эрхийн акт, стандартууд

Аудитыг Төв аймгийн Аудитын газрын менежер О.Амаржаргал удирдан, ахлах аудитор Ц.Базарсад аудитор Ж.Бямбацогт, шинжээч Хишигжаргал нар 2016 оны 9-р сарын 01-нээс 10-р сарын 05-ныг дуусталх хугацаанд хийж гүйцэтгэв.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн
хэрэгжилт

Асуудал 1

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтийг бодитой дүгнэхгүй байна

Аудитын зорилт 1 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, сумын ИТХ, Засаг дарга нь байгаль орчныг хамгаалах талаар хуульд заасан үүргийг биелүүлсэн эсэх

1.1 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах бүрэн эрхээ хэрэгжүүлсэн үү

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтийг бодитой дүгнэхгүй байна

Байгаль Орчин Аялал жуулчлалын газар нь Байгаль орчны чиглэлээр шинэчлэгдэн батлагдсан багц хуулиуд, холбогдох дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлж, 6 үндэсний хөтөлбөрийг 97.5 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

2015 онд Байгаль Орчин, Ногоон Хөгжил, Аялал Жуулчлалын сайд болон Төв аймгийн Засаг даргын хооронд хийсэн Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх талаар байгуулсан 14 арга хэмжээнд 732.2 сая төгрөг зарцуулахаар гэрээ хийгдсэн. Гэрээний хэрэгжилтийг дүгнэхэд Байгаль орчныг хамгаалах 14 арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 10 арга хэмжээ, 70 хувьтай 1 арга хэмжээ, 80 хувьтай 2 арга хэмжээ, хугацаа болоогүй 1 арга хэмжээ, хэрэгжилтийн дундаж хувь 96.1% буюу 4.80 үнэлэгдсэн байна.

2015 онд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн есдүгээр хуралдааны 02 тоот тогтоолын 4 дүгээр хавсралтаар байгаль орчныг хамгаалах арга хэмжээний жагсаалтыг 15 арга хэмжээнд 932.2 сая төгрөгөөр батлагдсаныг 2015 оны 3 дугаар сарын 27-ны аравдугаар хуралдааны 08 тоот тогтоолын 4 дүгээр хавсралтаар 9 арга хэмжээнд 593.4 сая төгрөг болгон тодотгосон байна.

**Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал нэр
төрлөөр /сая.төг/**

Арга хэмжээ	Сайдтай хийсэн гэрээний дүн	2014 оны 12 сард анхны батлагдсан	2015 оны 3 сард тодотгож баталсан	Хэрэгжсэн арга хэмжээ	гэрээний Хэрэгжилтийн хувь
Одонт хөтлийн дагуух Шинэчлэл цэцэрлэгт хүрээлэнд ойн зурвас байгуулах ажлыг үргэлжлүүлэх	180.0	180.0	61.4	68.9	100.0
Хөрсний бохирдлыг бууруулах хүрээнд гэр хороололыг цэвэр бохир усны байгууламжтай болгох			200.0	10.6	5.3
Баянцогт сумын үерийн хамгаалалтын даланг засаж тохижуулах төсөл хэрэгжүүлэх	161.5	161.5	161.5	161.5	100.0
БОУБайцаагч, БХамгаалагч нарын сургалт зохион байгуулах	6.0	6.0	4.8	4.8	100.0
Усны тооллого явуулах, ард иргэд, ААНБ-ийн оролцоог нэмэгдүүлэн сургалт суртчилгаа явуулах	5.0	5.0	5.0	5.0	100.0
Хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд цэвэрлэх байгууламж барих	80.0	80.0	80.0	80.0	100.0
Сумдын усны сав бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох	26.0	26.0	26.0	26.0	100.0
Төв суурин газрын агаарын бохирдлыг бууруулах төсөл хэрэгжүүлэх 100 өрх хамруулна	24.5	24.5	24.5		
Манзуширийн тусгай хамгаалалттай газрын орчны бүсийг тохижуулж, менежментийг боловсруулах	30.2	30.2	30.2	30.2	100.0
Ойн нөхөн сэргээх ажлыг нэмэгдүүлнэ	79.5	79.5			50.0
Ойн хортон шавж өвчнөөс хамгаалах судалгааны ажлыг явуулна	9.5	9.5			
Ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх	40.0	40.0			
Хог хаягдлын кодчилсон тооллогыг хийн, мэдээллийн санг нарийвчилан баяжуулна	20.0	20.0		20.0	100.0
Мэргэжлийн байгууллагаар ан агнуурын амьтдын нөөцийг тогтоох, агнуур зохион байгуулалт, менежментийн төлөвлөгөөг хийлгүүлэх	50.0	50.0			50.0
Булаг шандын эхийг хамгаалах ажлыг зохион байгуулна	20.0	20.0			
Бэлчээрийн мэргэгч оготно устгах зардал		200.0			
нийт дүн	732.2	932.2	593.4	387.0	
Зөрүүг тооцоход			338.8		

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал анхны батлагдсан төсвөөс 338.8 сая төгрөгөөр буурсаныг тодруулбал:

- Бэлчээрийн мэргэгч оготно устгах арга хэмжээний 200.0 сая төгрөгийн зардлыг хөрсний бохирдлыг бууруулах хүрээнд гэр хороололыг цэвэр бохир усны байгууламжтай болгох гэж өөрчилсөн.
- Одонт хөтлийн дагуух Шинэчлэл цэцэрлэгт хүрээлэнд ойн зурвас байгуулах ажлыг үргэлжлүүлэхэд 180.0 сая төгрөгийн зардал батлагдсаныг 118.6 сая төгрөгөөр бууруулсан.

- Ойн нөхөн сэргээх, ойн хөнөөлт шавьжтай тэмцэх, хог хаягдлын кодчилсан тооллого хийх, агнуурын зохион байгуулалт менежментийн төлөвлөгөө хийх, булаг шандны эхийг хамгаалах гэсэн 6 арга хэмжээний 219.0 сая төгрөгийн зардлыг сумдын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд батлуулахаар хасаж баталсан байна.

БОНХАЖЯамны сайдтай хийсэн гэрээний хэрэгжилтийг тулгахад :

- Төв суурин газрын агаарын бохирдлыг бууруулах төсөл хэрэгжүүлж 100 өрх хамруулна гэсэн 24.5 сая төгрөгийн ажил хийгдээгүй
- Ойн хортон шавьж өвчнөөс хамгаалах судалгааны ажлыг Баяндэлгэр, Мөнгөнморьт, Эрдэнэ суманд 100га-д 9.5 сая төгрөгөөр хийгдэхээр арга хэмжээнд тусгагдсаныг хийгээгүй байна.
- Ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх ажлыг Баяндэлгэр, Эрдэнэ, Мөнгөнморьт сумдад 2000 га-д 40.0 сая төгрөгөөр хийгдэхээр арга хэмжээнд тусгагдсаныг хийгээгүй
- Жаргалант суманд хийгдэх 15 га талбайд 10.4 сая төгрөгөөр Ойг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэх тендерт “Ойн бүргэд” ХХК, “Оюу цагаан барс” ХХК-ийн ирүүлсэн материал ерөнхий шаардлага хангаагүйгээс гүйцэтгэгч сонгогдоогүй тул хийгдээгүй.
- Мөнгөнморьт суманд хийгдэх ойг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгүүлэх тендерт 30 га талбайд 20.5 сая төгрөгөөр Сайхан санаа ХХК, Эрдэнэ сумын “Халзтайн эх” 15 га талбайд 10.4 сая төгрөгөөр “Ойн бүргэд” ХХК, Баянцогт сумын нутагт “мойлтын ам” 24 га талбайд 16.9 сая төгрөгөөр Говийн улиас ХХК, Батсүмбэр сумын “сувагт”-д 30 га талбайд 20.8 сая төгрөгөөр Чубад ХХК тус тус ойжуулалт хийхээр шалгарсан байна.

Харин эдгээр нөхөн сэргээлтийн арга хэмжээний зардлыг сумдын хурлаараа тодотгож батлаагүйгээс Мөнгөнморьт, Баянцогт, Эрдэнэ сумдад хийсэн ойжуулалтын 17.8 сая төгрөгийн санхүүжилт олгогдоогүй, хийгдсэн ойжуулалтын талбайг хүлээн авсан боловч амьдралтын хувийг тогтоогоогүй байна. Чубад ХХК нь Батсүмбэр сумын 30га-д ойжуулалт хийсэн гэсэн хэдий ч сумтай гэрээ хийгээгүй, ойжуулалтын тайланг ирүүлээгүй байхад аймгийн Засаг дарга, БОНХАЖСайдтай хийсэн гэрээний хэрэгжилтийг 96.1 хувиар тайлагнасан байна.


- Мэргэжлийн байгууллагаар ан агнуурын амьтдын нөөцийг тогтоох, агнуур зохион байгуулалт, менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлыг сумдын байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд тусгагдаагүй байхад Байгаль хамгаалах сангаас Бүрэн сумаас 2.0 сая төгрөг, Өндөрширээт сумаас 12.0 сая төгрөг тус тус шилжүүлсэн. Мөн Лүн сум 12.0 сая төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгасан, Алтанбулаг, Баян-өнжүүл сумдад тус бүр 12.0 сая төгрөг арга хэмжээний зардалд суугдаагүй байхад гэрээний хэрэгжилтийг биелэсэнээр тооцсон байна.

Гэрээнд тусгагдсан 14 арга хэмжээнээс 7 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 4 арга хэмжээ огт хэрэгжээгүй, 3 арга хэмжээ хагас хэрэгжсэн байна.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтийг бодитой дүгнэхгүй байна. Энэ нь Засгийн газрын 43 тогтоолын Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, тайлагнах журмын 4.2 “аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага нь энэхүү журмын 4.1-д заасан төлөвлөгөө, тайланг нэгтгэн боловсруулж жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

2014 онд улсын төсвөөр аймгийн ой зохион байгуулалтын судалгааны ажил хийгдсэн тул “ойн менежмент”-ийн шинэчилсэн төлөвлөгөөг дахин хийхээр бэлтгэл ажил бүрэн хангагдсан байна.

Аймгийн хэмжээний байгаль хамгаалах болон ойн нөхөрлөлүүдийн судалгааг шинэчлэн гарган авч мэдээллийн санг баяжуулсан байна. Ой бүхий 11 суманд 124 ойн нөхөрлөл 239.2 мянган га, 10 байгууллага аж ахуйн нэгж 39.5 мянган га талбайг гэрээгээр эзэмшин нийт 278.7 мянган га талбайг хамгаалж байна.



Аймгийн хэмжээгээр нийт 124 Ойн нөхөрлөлүүдийн менежментийг төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт 90% гэж дүгнэгдсэн байна.

Ойн нөхөрлөлүүд менежментийн төлөвлөгөөний дагуу Мөнгөнморьт сум 8, Жаргалант сум 12, Эрдэнэ сум 4, Батсүмбэр сум 6, нийт 30 ойн нөхөрлөлд ойн цэвэрлэгээгээр түлшний мод хийх зөвшөөрөл сумын ИТХТ-ийн тогтоолоор олгож орон

нутгийн иргэдийн хэрэгцээг хангаж байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15.1.4 “хууль тогтоомжийн дагуу жил бүр ашиглаж болох ой, ургамал, амьтны тоо хэмжээг тодорхойлж, экологийн шаардлага, нөөцийг харгалзан тухайн бүс нутагт байгалийн зарим төрлийн баялгийн ашиглалтыг хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох” гэсэн заалтын дагуу дараах шийдвэрүүд гарсан байна.Үүнд:

- 2014 онд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014.01.07-ны А/06 тоот тушаалаар ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг батласны дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014.01.27-ны өдрийн хоёрдугаар хуралдааны 09 тоот тогтоолоор ойн сангаас бэлтгэх модны хэмжээ, хуваарийг 39600м3-ээр баталсан.
- 2015 онд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014.10.31-ны А/382 тоот тушаалаар ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг батласны дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015.01.16-ны өдрийн 14 тоот тогтоолоор ойн сангаас бэлтгэх модны хэмжээ, хуваарийг 38000м3-ээр баталсан байна.
- 2016 онд ойн сангаас олгох модны хэмжээ хуваарийг аймгийн ИТХТ-ийн 2016.02.17 ны өдрийн 13 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар цэвэрлэгээний огтлолтоос хэрэглээний мод 9650м3, түлээний мод 28350м3-ыг, хоёрдугаар хавсралтаар “ойн цэвэрлэгээ” хөтөлбөрийн хүрээнд 16000 м3-ыг тус тус бэлтгэхээр баталсан байна.

2014 онд аймгийн хэмжээнд хэрэглээ 8250 м3, түлээ 27245 м3 нийт 35495 м3 мод олгож орон нутгийн төсөвт 196.2 сая төгрөг оруулсан байна.

2015 онд аймгийн хэмжээнд хэрэглээ 5427 м3, түлээ 22782 м3 нийт 28209 м3 мод олгож орон нутгийн төсөвт 156.8 сая төгрөг оруулсан байна.

Бэлтгэсэн модны хэмжээг харуулбал / шоо метр /



2014 онд Байгаль орчин ногоон хөгжлийн яамнаас А/06 тоот 3 дугаар хавсралтаар Ойн сангүй болон ойн ашиглах нөөцгүй аймаг, нийслэл, хотуудын хэрэгцээг хангах зорилгоор ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг манай аймагт нийт түлээ 140400 м3, хэрэглээ 24780 м3-ээр баталж ирүүлсэн.

Монгол улсын Засгийн газрын 2014 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “ойн цэвэрлэгээ” хөтөлбөрийн хүрээнд бэлтгэх модны хэмжээг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 56 дугаар тогтоолын дагуу Улаанбаатар хотын болон ойн нөөцгүй сумдын мод модон материалын хэрэгцээнд бэлтгэх модны хэмжээг аймгийн ИТХ-аар Батсүмбэр, Мөнгөнморьт суманд бэлтгүүлэхээр жил бүр баталж өгсөн байна.


Аймаг, сумын хурлаар батлагдсан бэлтгэх модны хэмжээ /м3/

Сум	зориулалт	2014 он			2015 он		
		яам	аймаг	сум	яам	аймаг	сум
Мөнгөнморьт	түлээ		20000	20000		6000	11800
	хэрэглээ		1770	1770		2000	1770
Батсүмбэр	түлээ		20000	20000		6000	13660
	хэрэглээ		1770	1770		2000	1650
Нийт дүн	Түлээ	140400	40000	40000	134448	12000	25460
	хэрэглээ	24780	3540	3540	30731	4000	3420

Хүснэгтээс үзэхэд 2015 онд аймгийн ИТХурлаар батлагдсан “ойн цэвэрлэгээ” хөтөлбөрийн хүрээнд бэлтгэх модны хэмжээг тусгай зөвшөөрөл авсан мэргэжлийн аж ахуйн нэгж байгууллагуудад сумын ИТХ-аас хуваарилахдаа түлээ бэлтгэх хэмжээг нэмэгдүүлж, хэрэглээг бууруулж баталсан байна. Энэ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.1.2 “нутаг дэвсгэртээ тухайн жилд ашиглах байгалийн баялгийн нөөцийн дээд хэмжээг энэ хуульд заасан үндэслэл журмын дагуу тогтоох, Ойн тухай хуулийн 17.1.4 “төрийн захиргааны төв байгууллагын баталсан дээд хязгаарт багтаан тухайн жилд ойгоос бэлтгэх хэрэглээний мод, түлээний хэмжээг сумдаар хуваарилан батлах”, 17.2.4 “тухайн жилд ойгоос бэлтгэх модны хэмжээний талаарх саналаа төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Аймгийн хэмжээнд ойн хөтөлбөрийн хүрээнд арчилгаа, цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэсэн модны 100 м3 тутамд 1.5 га талбайд ойжуулалт хийх заалтын дагуу 9 аж ахуйн нэгж, 1 нөхөрлөл нийт 142 га-д 2 настай шинэс, нарс өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийсэн байна.

Ойжуулалт хийсэн талбай /га/-аар




Аймгийн хэмжээнд улсын болон орон нутгийн төсөв, өөрийн хөрөнгөөр 20 байгууллага аж ахуйн нэгж нийт 410 га-д ой нөхөн сэргээх ажлыг хийж 284.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

МУ-ын ЗГ-ын 2014.02.07-ний 30-р тогтоолоор батлагдсан “Ойн хөтөлбөр”-ын хавсралтын 3.1.5-д Ойгоос цэвэрлэгээгээр бэлтгэх модны 100 шоометр тутамд 3га талбайд ой тарьж ургуулах ажлыг холбогдох нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагаар гүйцэтгүүлэх гэж заасны хэрэгжилтийг Мөнгөнморьт суманд ажиллахдаа шалгалаа. Мөнгөнморьт сумын ИТХ-ийн тогтоолоор ойн сангаас мод бэлтгэх зөвшөөрөл олгож, мод бэлтгэсэн хэрэглээний модны 100 шоометр тутамд 3 га талбайд ойжуулалтын ажлыг холбогдох аж ахуйн нэгж байгууллага өөрийн хөрөнгөөр хийлгэхээр баталсны дагуу 2014-2016 онуудад дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

- 2014 онд Хөх дөрвөлжин ХХК 56 га, Сайхансанаа ХХК 107 га, Мөнх эвийн хүч ХХК 4.5 га нийт 167.5га –д хийсэн
- 2015 онд Хөх дөрвөлжин ХХК 33 га, Сайхансанаа ХХК 39 га, Эковорлд ХХК 21 га, Мөнх эвийн хүч ХХК 7.5 га нийт 100.5 га-д хийсэн. Мөн Сайхан санаа ХХК нь Хан хэнтийн тусгай хамгаалалттай газрын даргатай байгуулсан гэрээний дагуу ХХТХГазрын нутаг Боргуя хэмээх газарт 30 га газарт ойжуулалтыг хийсэн байна.
- 2016 онд БОНХАЖ-ын сайдын “2016 онд ойгоос бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай” 2015.12.04-ний өдрийн а/415 тоот тушаалын 6-д заасны дагуу сумын ИТХ-ын тогтоолоор мод бэлтгэсэн хэрэглээний модны 100 шоометр тутамд 1.5 га талбайд ойжуулалт хийхээр баталсан. Үүний дагуу 2016 оны эхний 8 сарын байдлаар ойжуулалтыг хүлээн авсан актаар Сайхансанаа ХХК 22га, Эковорлд ХХК 7.5 га, Хөх дөрвөлжин ХХК 18.5 га, Мөнх эвийн хүч 6.5 га, Тэнүүн зоргол 4 га нийт 58.5 га –д ойжуулалт хийгдсэнийг хүлээн авсан байна.
- 2016 онд сумын ИТХ-ын тогтоолоор мод бэлтгэсэн хэрэглээний модны 100 шоометр тутамд 1.5 га талбайд ойжуулалт хийхээр баталсан. Үүний дагуу 2016 оны эхний 8 сарын байдлаар хүлээн авсан актаар Сайхансанаа ХХК 22га, Эковорлд ХХК 7.5 га, Хөх дөрвөлжин ХХК 18.5 га, Мөнх эвийн хүч 6.5 га, Тэнүүн зоргол 4 га нийт 58.5 га –д ойжуулалт хийгдсэнийг хүлээн авсан байна.

Мөнгөнморьт сумын сум дундын ойн анги Баруун бүрхэд 6 га мод үржүүлгийн газар шинээр байгуулж 20х 6м –ийн 2 хүлэмж, ил талбайг боловсруулан шилмүүст болон навчит модны үр мөчир тарьж худаг гаргасан байна. Батсүмбэр сумын сум дундын ойн анги Үдлэгт 2 хүлэмж байгуулан тарилт хийсэн байна. Энэ ажилд орон нутгийн төсвөөс 10.5 сая төгрөг зарцуулжээ.

Аймгийн хэмжээнд 2015 онд 8 сумын 16 мод үржүүлгийн газар шилмүүст модны 653.1мянган тарьц, навчит модны 998.4 мянган суулгац тус тус ургуулсан байна.



Ойн хөнөөлт шавьж өвчний судалгааны ажлыг 170.1 мянган га-д Батсүмбэр, Эрдэнэ, Мөнгөнморьт, Баяндэлгэр сумдад хийв.

Судалгааны материалыг үндэслэн “Гранд- форест” ХХК нь Эрдэнэ, Мөнгөнморьт, Баяндэлгэр сумдад 1300 га-д ойн хөнөөлт шавьж өвчний тэмцлийн ажлыг орон нутгийн төсвөөр хийсэн. Мөн улсын төсвийн хөрөнгөөр Батсүмбэр суманд МБОНБХолбоо ТББ 9500 га-д, Мон-таксаци ХХК 5000 га-д ой хортны тэмцлийн ажлыг явуулж нийт аймгийн хэмжээнд 15800 га-д тэмцлийн ажил хийгдсэн байна.

2015 оны 12 дугаар сард зохион байгуулагдсан усны тооллогын дүнгээр аймгийн хэмжээнд газрын доорхи усны хяналт шинжилгээний 16 цооногтой болоод байна. Газрын тос, Уул уурхай эрхлэгч ААН байгууллагууд өөрийн хөрөнгөөр газрын доорхи усны хяналт шинжилгээний цооног гаргасан байна.

1.2 Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв батлаж биелэлтэд хяналт тавих бүрэн эрхээ хэрэгжүүлсэн үү?

Төсөл арга, хэмжээний зардлын төсвийн гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна

Аймгийн Байгаль хамгаалах сан нь 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2010 оны 31 дүгээр тогтоолоор баталсан “Аймаг, сумын байгаль орчныг хамгаалах санд хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын дагуу үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2-т “Аймаг өөрийн төсвөөр тухайн шатанд хамаарах дараах чиг үүргийг бие даан хэрэгжүүлэх”, 58.2.13-т “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх”, “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 2 дугаар сарын 14-ний 43 дугаар тушаалаар баталсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 13.4-т заасны дагуу засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, сумдын иргэдийн төлөөлөгчдийн хуралаар батлуулж ирсэн байна.

2014 онд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зургаадугаар хуралдааны 2013 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 тоот тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар байгаль орчны чиглэлээр хийх ажлын 26 арга хэмжээг 932.2 сая төгрөгөөр баталсан. Мөн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын наймдугаар хуралдааны 2014 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн 08 тоот тогтоолоор 2014 оны шилжих үлдэгдлээс байгаль орчны чиглэлээр 6 арга хэмжээнд 425.0 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.

2014 онд Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд батлагдсан төсвөөр хийж гүйцэтгэсэн 6 арга хэмжээ нь зорилтот үр дүндээ нийцсэн байна. Үүнд:

- Усыг зүй зохистой ашиглах, хамгаалах арга хэмжээнд 3 ажил
- Цөлжилтийг сааруулах ажилд 3 арга хэмжээ
- Ойн нөхөн сэргээлт, ойжуулалтын арчилгааны ажилд 8 арга хэмжээ
- Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас эвдрэл, доройтолд орж нөхөн сэргээгдэлгүй орхигдсон газруудын экологийн хохирлыг мэргэжлийн байгууллахаар тооцуулах 1 арга хэмжээ

- Хог хаягдлын менежментийг сайжруулах ажилд 2 арга хэмжээ
- Ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, иргэд, хүүхэд залуусын экологийн боловсролыг дээшлүүлэх ажилд 3 арга хэмжээ

2014 онд төлөвлөгдсөн арга хэмжээнээс сумдын байгаль хамгаалагч, байгаль орчны улсын байцаагч, ойн ангийн дарга, мэргэжилтнүүдийн нормын хувцас, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслэлийн шинэчлэлд 114.0 сая төгрөг төлөвлөсөн нь зорилтот үр дүндээ нийцэхгүй байна

Эрдэнэ, Баяндэлгэр, Мөнгөнморьт суманд 20.0 сая төгрөгөөр “механик аргаар ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх” 1 ажил хэрэгжээгүй байна.

2015 онд Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн есдүгээр хуралдааны 02 тоот тогтоолын 4 дүгээр хавсралтаар байгаль орчныг хамгаалах арга хэмжээний жагсаалтыг 15 арга хэмжээнд 932.2 сая төгрөгөөр батлагдсаныг 2015 оны 3 дугаар сарын 27-ны аравдугаар хуралдааны 08 тоот тогтоолын 4 дүгээр хавсралтаар 2015 онд байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 9 арга хэмжээнд 593.4 сая төгрөгөөр буюу 338.8 сая төгрөгөөр хасаж тодотгон батласан байна.

2015 онд Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд батлагдсан төсвөөр хийж гүйцэтгэсэн 6 арга хэмжээ нь зорилтот үр дүндээ нийцсэн байна. Үүнд:

1. Зуунмод сумын Шинэчлэл цэцэрлэгт хүрээлэнд ойн зурвас байгуулах ажлыг үргэлжлүүлэн дуусгах,
2. Баянцогт сумын Үерийн хамгаалалтын даланг засаж тохижуулах төсөл хэрэгжүүлэх,
3. Сумдын БОХ-ын улсын байцаагч, байгаль хамгаалагч, сум дундын ойн анги, идэвхтэн байгаль хамгаалагчдын сургалт зохион байгуулах,
4. Усны тооллогыг явуулж, сав газруудын зөвлөлийн үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, ААН байгууллагын оролцоог нэмэгдүүлэн сургалт сурталчилгаа явуулах.
5. Сумдын усны сан бүхий газрын хамгаалалтын бүс тогтоох төсөл арга хэмжээний нэр байршил тогтоох
6. Сүмбэр сумын Хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Цэвэрлэх байгууламж барих ажлууд

2015 онд төлөвлөгдсөн арга хэмжээнээс Хөрсний бохирдлыг бууруулах ажлын хүрээнд гэр хорооллыг цэвэр, бохир усны байгууламжтай болгох ажил, Төв суурин газрын агаарын бохирдлыг бууруулах төсөл хэрэгжүүлэх ажлыг тус тус хийж гүйцэтгээгүй дараа онд үргэлжлүүлэн хийж гүйцэтгэхээр болсон байна.

Манзуширын тусгай хамгаалалттай газрын орчны бүсийг тохижуулах, менежментийг сайжруулах нэрээр батлагдсан энэ төсөл арга хэмжээг Музейн барилгын өргөтгөлийн зураг төсвийг хийлгэн зориулалтыг өөрчилсөн нь зорилтот үр дүндээ нийцэхгүй байна.

2016 онд Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн арваннэгдүгээр хуралдааны 09 тоот тогтоолын 4 дүгээр хавсралтаар байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 2 арга хэмжээнд 486.3 сая төгрөгөөр батлагдсанаас 248.0 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэсэн байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл арга, хэмжээний зардлыг жил бүр баталж байгаа боловч гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна.

1.3 Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах бүрэн эрхээ хэрэгжүүлсэн үү?

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж гарсан шийдвэрийн биелэлтийг хангуулж ирсэн байна

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйл, 16 дугаар зүйлүүдэд “байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцлийг хангах, байгаль орчинд учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгуулах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэж заасны дагуу дараах хөтөлбөрүүдийг аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталж үе шаттайгаар хэрэгжүүлж ирсэн байна.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2011 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор “Аймгийн ойн дэд хөтөлбөр”, түүнийг хэрэгжүүлэх II үе шатны арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 97.5 хувиар хангалттай гэж дүгнэж, III үе шатны арга хэмжээний төлөвлөгөөг 2011-2015 онд хэрэгжүүлэхээр 6 зорилт, 64 арга хэмжээг төлөвлөж баталсан байна.

Ойн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх III үе шатны төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор Аймгийн ИТХТ-ийн хуралдааны 2011 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 04 тоот тогтоолоор 4 заалт, 2014 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 16 тоот тэмдэглэлээр 16 заалт, 2015 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 24 тоот аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны тэмдэглэлээр 11 заалтаар өгөгдсөн үүргийн хэрэгжилтийг жил тус бүрээр нь гаргаж шийдвэрлэж ирсэн байна.

Монгол улсын Засгийн газраас баталсан “ус үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор 2006 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 02 тоот аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын долдугаар хуралдааны тогтоолоор аймгийн хэмжээнд “усны талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх хугацааг эхний үе шатыг 2007-2010 онд, хоёр дахь үе шатыг 2011-2015 онд хэрэгжүүлэхээр баталсан.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 128 тоот тогтоолоор “Аймгийн усны талаар баримтлах бодлого”, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний эхний үе шатны хэрэгжилтийг хэлэлцээд, хоёр дахь үе шатны “ус үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2011-2015 онд хэрэгжүүлэхээр 6 зорилт, 45 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилтийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд өргөн барьсанаар хэрэгжилт 88.4 хувь буюу хангалттай гэсэн үнэлгээ авсан байна.

“Ан амьтны тухай хууль”-ийн 5 дугаар зүйл, “Аймгийн хэмжээнд ан амьтадыг хамгаалах, зохистой ашиглах, сэргээн нутагшуулах бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилгоор 2006 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 56 тоот аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор “Аймгийн хэмжээнд ан амьтдыг хамгаалах, зохистой ашиглах, өсгөн үржүүлэх бодлого”-ыг баталсан.

2015 онд “аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө”-г мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэн БОНХАЖЯамаар батлуулсан байна. 2016 оны 10 дугаар сард сум дамжсан агнуурын амьтны тархац нутагт ан амьтныг агнах, барих агнуурын бүс нутгийг тогтоолгож, менежментийн төлөвлөгөөг боловсруулан аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулахаар төлөвлөөд байна.

“Цөлжилттэй тэмцэх дэд хөтөлбөр”-ийг 2013-2016 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 1 зорилго, 4 зорилт, 64 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 03 сарын 27-ны өдрийн Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн 42 дүгээр Тогтоолоор батлуулсан байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 49 дугаар тогтоолоор баталсан “Хог хаягдлыг бууруулах аймгийн дэд хөтөлбөр /2013-2016/-ийг хэрэгжүүлэх 2-р үе шатны төлөвлөгөөний хэрэгжилтийг гарган аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд өргөн барьсанаар хэрэгжилт 86.8 хувь буюу хангалттай дүгнэгдсэн байна.

Зуунмод сумын төвлөрсөн хогийн цэгт байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг хийлгэх ажлыг зохион байгуулж, БОНХАЖЯ-ны 2015 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 08/709 дугаар албан тоотой байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэн дүгнэлт гаргуулсан.

БОНХАЖСайдаас 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 1/3453 дугаар албан бичгээр өгсөн үүрэг чиглэл болон батлагдсан удирдамжийн дагуу тооллогод хамрагдах өрх, ам бүлийн тоог аймгийн 2014 оны статистик мэдээг үндэслэн гаргасан бөгөөд зуны тооллогод 1628 өрх буюу аймгийн нийт өрхийн 5.6% нь хамрагдсан байна.

“Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах, санхүүжүүлэх журам”-ын төслийг боловсруулан, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 01-р сарын 16-ны өдрийн 16 тоот тогтоолоор батлуулж, батлагдсан журмыг мөрдөн ажиллахыг Сумдын Засаг дарга нарт үүрэг болгон ажиллаж байна.

Монгол улсын ерөнхийлөгчийн 2014 оны 48 дугаар зарлиг, БОНХСайдын баталсан “Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх” ажлыг эрчимжүүлэх аяны удирдамжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан батлуулж сумдад хүргүүлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Ой хээрийн түймрээс хамгаалах халз зурвас байгуулах ажлыг гүйцэтгэх байгууллага, аж ахуйн нэгжүүд байхгүй, таримал ойд хүлээлгэн өгөх стандартад нийцсэн таримал ой байхгүй, судалгааны төдий ажил явагдсан гэж дүгнэгдсэн байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны тэмдэглэлүүдээр нийт 76 заалт бүхий үүрэг өгөгдсөнөөс байнга мөрдөх 8 заалт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх 68 заалтуудыг хэрэгжүүлж ирсэн нь Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ боловсруулж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж гарсан шийдвэрийн биелэлтийг хангуулж ирсэн байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт

Асуудал 2

Хүн амын ундны болон ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөөгүй байна.

2. Байгалийн нөөц ашигласаны төлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төлөвлөж бүрэн төвлөрүүлсэн эсэх.

2.1. Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөсөн үү?

Хүн амын ундны болон ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөрөөс бусад байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөсөн байна.

Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцлийг хангах, байгаль орчинд учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгуулах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг

зохион байгуулах арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлого бүрдүүлэлтийн байдалд 2014-2015 онууд болон 2016 оны эхний хагас жилийг хамруулан аудит хийв.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудын дагуу байгалийн нөөцийн төлбөрийн орлого буюу ойгоос мод ашигласаны төлбөр, ан агнах зөвшөөрлийн хураамж, ус ашигласаны төлбөр, байгалийн ургамал ашигласаны төлбөрийн орлогуудыг орон нутгийн төсөвт буюу суманд төвлөрүүлэх, үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашигласаны төлбөрийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр тогтсон байна.

Сум тус бүр өөрсдийн газар зүйн байршил, ойн сангийн нөөц, ан амьтан, ургамалын тархац болон эдгээрт үндэслэн мэргэжлийн байгууллагуудын гаргасан менежментийн төлөвлөгөөны дагуу тухайн жилд ашиглах байгалийн нөөцийг тогтоолгож, холбогдох журам, аргачлалын дагуу байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлогыг төлөвлөн аймгийн Байгаль Орчины Газар болон, Санхүү Төрийн Сангийн Хэлтэсээр хянуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулдаг байна.

Байгалийн нөөц ашигласаны орлогын төлөвлөгөөг аймгийн дүнгээр он тус бүрээр харуулав.

/ сая төгрөгөөр/

№	Нэр төрөл	2014 он	2015 он	2016 он
	Нийт орлого	1656.8	1963.9	1952.2
	Орон нутгийн орлого /суманд/	304.8	406.8	562.9
1	Ойгоос мод ашигласаны төлбөр	176.6	234.6	215.2
2	Ан агнах зөвшөөрлийн хураамж	30.5	56.0	131.2
3	Ус ашигласаны төлбөр	61.3	77.7	17.8
4	Ургамал ашигласаны төлбөр	36.3	38.6	38.6
	Аймгийн төсвийн орлого	1352.1	1557.1	1389.3
1	Ус ашигласаны төлбөр	1352.1	1557.1	1389.3

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 12-р сарын 3-ны өдрийн 03 тоот тогтоолоор 2014 онд аймаг, орон нутгийн төсөвт байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлогыг 1656.8 сая төгрөг, 2014 оны 12-р сарын 08-ны өдрийн 04 тоот тогтоолоор 2015 онд аймаг, орон нутгийн төсөвт байгалийн баялаг ашигласаны төлбөрийн орлогыг 1963.9 сая төгрөг, 2015 оны 12-р сарын 27-ны өдрийн тоот тогтоолоор 1952.2 сая төгрөгөөр тус тус төлөвлөсөн байна.

Ойгоос мод ашигласны төлбөрийг Алтанбулаг, Батсүмбэр, Баяндэлгэр, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Заамар, Мөнгөнморьт, Сүмбэр, Угтаал, Цээл, Эрдэнэ, Эрдэнэсант зэрэг сумдад ногдуулалт хийсэн байна. Эдгээр сум тус бүрд ойн менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллага болох Гранд Форест ХХК-аар 3-5 жилийн хугацаатайгаар хийлгэж ойгоос бэлтгэх модны тоо хэмжээ, төрөл зүйлийг тогтоож өгсөн байна.

Засгийн газрын 2014 оны 9 сарын 18-ны 307 тоот “Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын дагуу модыг хэрэглээ, түлээ, арчилгаа, цэвэрлэгээний аргаар мод бэлтгэх зэргээр ангилсан төлбөрийн хувь хэмжээгээр орон нутгийн ойн нөөц, модны төрөл зүйлд зохицуулан жил бүр өөр хэмжээгээр орлогыг ногдуулсан байна.

Аймгийн хэмжээнд Батсүмбэр, Мөнгөнморьт, Жаргалант, Эрдэнэ, Борнуур сумдын газар нутаг ойн нөөцийн ихэнх хувийг эзэлдэг ба бусад сумдын газар нутагт ойн нөөц харьцангуй бага голын дагуух бургас зэргээс ойн нөөц бүрддэг байна.

Ойн нөөц бүхий сумдын ой мод ашигласаны төлбөрийн орлогын төлөвлөгөөг он тус бүрээр харуулав.

/ сая төгрөгөөр/

	Сумдын нэрс	2014 он	2015 он	2016 он
1	Алтанбулаг	0.3	0.3	0.3
2	Батсүмбэр	47.4	68.8	6.8
3	Баяндэлгэр	6.1	7.2	7.2
4	Баянцогт	6.1	6.2	5
5	Баянчандмань	2.9	5.2	4.7
6	Борнуур	10	12.7	10
7	Жаргалант	17.9	27.1	17
8	Заамар	0.2	0.8	0.3
9	Мөнгөнморьт	59.2	75.3	75
10	Сүмбэр	0.6	1.2	0.7
11	Угтаал	4.2	5	4.5
12	Цээл	2.2	4.2	4.3
13	Эрдэнэ	19.2	20.2	16
14	Эрдэнэсант		0.3	
	Нийт	176.6	234.6	151.8

Ан агнах зөвшөөрлийн хураамжийг төлөвлөхдөө 2014-2016 онд ангийн орлогыг Алтанбулаг, Батсүмбэр, Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Бүрэн, Лүн, Мөнгөнморьт, Өндөрширээт сумдад ногдуулсан байна. Үүнд аргаль, угалз, буга, бор гөрөөс, зэрлэг гахай, загас, цагаан зээр, саарал чоно зэрэг амьтад багтаж байна.

Аймгийн Засаг дарга тухайн орон нутгийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага нь нутаг дэвсгэртээ ерөнхий агнуур зохион байгуулалт, менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэж аймгийн ИТХ-аар хэлэлцүүлдэг, тухайн агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч иргэн, хуулийн этгээд нь ан агнуурын менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээр, сум дамжсан агнуурын бүс нутгийн агнуурын менежментийн төлөвлөгөөг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээр хэлэлцүүлдэг байна.

Аймгийн хэмжээнд ерөнхий агнуур зохион байгуулах судалгаа болон ан агнуурын менежментийн төлөвлөгөөг “Эко үйлчилгээ” ТББ-аар хийж гүйцэтгүүлэн түүнд тулгуурлан тухайн жилд ан агнуурын бүс нутаг, ан агнуурын тоо толгойг тогтоосон байна.

БОНХ-ийн сайдын 2014 оны 12-р сарын 04-ны өдрийн А-420 дугаар тушаалаар 2015 онд тусгай зориулалтаар амьтан агнах хуваарийг батласан мөн 2015 оны 5-р сарын 26-ны өдрийн БОНХАЖ-ын сайдын А-214 дугаар тушаалаар тусгай зориулалтаар 2015 онд агнах, барих амьтаны тоо хэмжээг агнуурын бүс нутагт нэмэлтээр хуваарилсан байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 1-р сарын 29-ны өдрийн 12 тоот тогтоолоор БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/446 тоот тушаалаар баталсан хуваарьт үндэслэн 2016 онд тусгай зориулалтаар агнах, барих ан амьтаны тоог тогтоож түүнээс орох орлогын хэмжээг сум түс бүрээр төлөвлөсөн байна.

Ан агнах зөвшөөрлийн хураамжийн орлогыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор агнах, барих амьтадын дээд хязгаарыг тогтоож түүнд баримтлан орлогын төлөвлөгөөгөө боловсруулдаг байна.

Ан агнах зөвшөөрлийн орлогын төлөвлөгөөг он тус бүрээр харуулав.

/сая төгрөгөөр/

№	Сумдын нэрс	2014 он	2015 он	2016 он
1	Алтанбулаг	8.8	10.8	29.7

2	Батсүмбэр	0.8	0.8	0.6
3	Баяндэлгэр	0.2	0.2	0.2
4	Баян-Өнжүүл	10.8	27.2	29.7
5	Бүрэн			14.9
6	Лүн			29.7
7	Мөнгөнморьт	1.1	0.8	0.8
8	Өндөрширээт	8.8	16.2	25.6
	Нийт	30.5	56.0	131.2

Ус ашигласаны төлбөрийг төлөвлөхдөө 27 сумын газрын гадарга болон гүний ус, рашаан ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөж БОНХ-ийн сайдын 2014 оны тушаалаар хоногт хэрэглэх усны хэмжээг 50 шоометр хүртэлх, 50-100, 100-аас дээш гэж 3 ангилан усны дүгнэлт болон төлбөрийн гэрээг аймгийн Байгаль орчны газар, сав газрын захиргаа, “Монгол ус” ТӨҮГазрууд шат шатандаа гэрээ байгуулж ногдуулдаг байна.

Засгийн газрын 2013 оны 327-р тогтоолын дагуу усны ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүрийг ашиглан төлөвлөж байна. Сумдад үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа усны төлбөрийн орлогын 95 орчим хувь нь аймгийн төсөвт төвлөрдөг байна.

Ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг зөвхөн ус, рашаан бүхий сумдад ногдуулж төлөвлөсөн байгаа нь Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн тухай хуулийн 10.1.2-т “хүн амын ундны болон ахуйн зориулалтаар ашигласан усыг шоо метрээр тооцож төлбөр ногдуулна” гэсэнтэй нийцээгүй байна.

Хүн амын ундны болон ахуйн зориулалтаар ашиглах усны төлбөрийн орлогыг бүх суманд төлөвлөж ногдуулалт хийгээгүй байна. Ус ашигласаны төлбөрийн орлогыг 2015 онд өмнөх оноос нэмэгдүүлж төлөвлөсөн бол 2016 онд өмнөх оноос бууруулж төлөвлөсөн байна.

2014 онд аймгийн Аудитын газраас үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашигласаны төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх талаар санал дүгнэлт өгсөний дагуу тухайн жилээс дээрх орлого харьцангуй нэмэгдэж бодитой төлөвлөгдөж байна.

Хүн амын ундны болон ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөөгүй байна.

Ус ашигласаны төлбөрийн орлогын төлөвлөгөөг сум тус бүрээр онуудаар харуулав.

/сая төгрөгөөр/

№	Сумдын нэрс	2014 он		2015 он		2016 он	
		Ахуйн ус	Үйлдвэрлэлийн ус	Ахуйн ус	Үйлдвэрлэлийн ус	Ахуйн ус	Үйлдвэрлэлийн ус
1	Алтанбулаг	1.9	3.4	1.6	15.0	0.6	9.0
2	Аргалант		2.5				1.8
3	Архуст	0.2		0.2	0.10	0.2	0.4
4	Батсүмбэр		2.0		2.5		2.8
5	Баян		31.3	1.0	31.0		16.9
6	Баяндэлгэр	0.2	0.2	0.2	0.7	0.2	0.7
7	Баянжаргалан		11.9	0.5	12.0		
8	Баян-өнжүүл		0.5		0.5		1.7
9	Баянцагаан	1.2		0.8		0.3	0.9
10	Баянцогт	0.3	1.9	0.3	1.8	0.3	1.2
11	Баянчандмань		17.6		21.5		27.2
12	Борнуур		9.3	0.1	2.2		
13	Дэлгэрхаан		1.2		2.5	0.3	2.9
14	Жаргалант	8.6	80.4	17.8	85.0		91.8
15	Заамар		861.0		1021.9		888.9
16	Зуунмод	9.7	24.5	3.5			5.0

17	Лүн	0.4		0.7		0.3	
18	Мөнгөнморьт		1.0		0.8		0.9
19	Сүмбэр	0.4		0.5			0.3
20	Сэргэлэн	0.2	262.1	0.7	290.2		296.1
21	Цээл		9.8		8.3		6.3
22	Угтаал-Цайдам		3.8				
23	Эрдэнэ	36.2	27.8	49.7	50.0	15.5	34.2
24	Эрдэнэсант			0.1	11.0		
	Нийт	61.3	1352.1	77.7	1557.1	17.9	1389.3

Ургамал ашигласаны төлбөрийг төлөвлөхдөө Батсүмбэр, Жаргалант, Мөнгөнморьт, Эрдэнэ сумдад ховор болон элбэг ургамлын ангиллаар орлого төлөвлөгдсөн байна. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны А-415 тушаалаар батлагдсан ургамлын экологи эдийн засгийн үнэлгээг баримтлан боловсруусан байна. Батсүмбэр суманд нохойн хошуу, Жаргалант суманд халгай, Мөнгөнморьт суманд нохойн хошуу, гүзээлзгэнэ зэргийг элбэг ургамалд мөн долоогоньг ховор ургамалд тооцон төлбөр хураамжыг төлөвлөсөн байна.

Мөн энэ төрлийн орлогод ойн дагалт нөөц буюу хуш модны самар түүх хураамжаас орох орлогыг төлөвлөсөн ба энэ нь тухайн жилийн байгаль цаг уурын нөлөөллөөс шууд хамааралтай тул харьцангуй бага хэмжээгээр төлөвлөгдөж, гүйцэтгэлийн хувь өндөртөй байдаг байна.

2015 онд БОНХАЖ-ын сайдын тушаалаар Батсүмбэр, Мөнгөнморьт сумдад самар түүх зөвшөөрөл олгосон бол Эрдэнэ, Баяндэлгэр сумдад хуш модны самарыг түүж бэлтгэхийг хориглосон байна. 2016 онд БОНХАЖ-ын сайдын А/17 тоот тушаалаар Батсүмбэр, Мөнгөнморьт суманд үйлдвэрлэлийн зориулалтаар самар түүх зөвшөөрөл олгож Эрдэнэ суманд хориглосон байна.

Ургамал ашигласаны төлбөрийн орлогын төлөвлөгөөг сум тус бүрээр онуудаар харуулав.

/сая төгрөгөөр/

№	Сумдын нэрс	2014 он	2015 он	2016 он
1	Алтанбулаг			
2	Батсүмбэр	0.2	0.3	
3	Жаргалант	0.8	2.0	1.0
4	Мөнгөнморьт	35.3	35.2	5.0
5	Эрдэнэ		1.1	
	Нийт	36.3	38.6	6.0

Хүн амын ундны болон ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөрөөс бусад байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлогыг бодитой төлөвлөсөн байна.

2.2. Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлогыг төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрүүлсэн үү?

Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлогыг төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрүүлсэн ба зарим суманд ан агнах зөвшөөрлийн хураамжийн орлого төлөвлөөгүй байхад орлого төвлөрүүлсэн байна.

Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлого төвлөрүүлсэн байдлыг аймгийн хэмжээгээр он тус бүрээр авч үзлээ. 2014 онд ойгоос мод ашигласаны төлбөрийн орлого 18.5 сая төгрөг буюу 11.0 хувиар давсан, ан агнах зөвшөөрлийн хураамжийн орлого 115.7 сая төгрөг буюу 4.7 дахин давсан, ургамал ашигласаны орлого 155.8 сая төгрөг буюу 5.3 дахин давж биелсэн бол ахуйн зориулалтаар ус ашигласаны орлого 3.9 сая төгрөг буюу 6.5 хувиар тасарсан байна.

Үйлдвэрлэлийн зориулалтаар ус ашигласаны орлого 626.6 сая төгрөг буюу 46,3 хувиар давж биелсэн байна.

2015 онд ойгоос мод ашигласаны орлого 83.5 сая төгрөг буюу 35.7 хувиар, ахуйн зориулалтаар ус ашигласаны төлбөрийн орлого 18.9 сая төгрөг буюу 24,4 хувиар тус тус тасарсан байна. Харин ан агнах зөвшөөрлийн хураамжийн орлого 196.4 сая төгрөг буюу 4.5 дахин, ургамал ашигласаны орлого 156.2 сая төгрөг буюу 5 дахин давж орсон байна.

2016 оны эхний 7-р сарын байдлаар гүйцэтгэлийг гаргасан ба байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлогыг жилийн эцэст бүрэн төвлөрүүлнэ гэж тооцоолсон байна.

Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлого төвлөрүүлсэн байдлыг он тус бүрээр харуулав.

/сая төгрөгөөр/

№	Нэр төрөл	2014 он		2015 он		2016 он	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
	Нийт орлого	1656.8	2569.4	1963.9	2319.3	1952.2	605.9
	Орон нутгийн орлого /суманд/	304.7	5907.7	406.8	656.9	562.9	94.1
1	Ойгоос мод ашигласаны төлбөр	176.6	195.1	234.6	151	215.2	61.9
2	Ан агнах зөвшөөрлийн хураамж	30.5	146.2	56	252.4	131.2	5.4
3	Ус ашигласаны төлбөр	61.3	57.3	77.7	58.8	177.9	26.8
4	Ургамал ашигласаны төлбөр	36.3	192.1	38.5	194.7	38.6	
	Аймгийн төсвийн орлого	1352.1	1978.7	1557.1	1662.4	1389.3	511.8
1	Ус ашигласаны төлбөр	1352.1	1978.7	1557.1	1662.4	1389.3	511.8

Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлого төвлөрүүлсэн байдлыг орлогын төрөл тус бүрээр сумдаар нь авч үзлээ.

Ойгоос мод ашигласаны төлбөрийн орлогыг нийт 2014 онд 13 суманд төлөвлөсөн ба 2015 онд 14 суманд төлөвлөсөн байна.

2014 онд энэ төрлийн орлого нь нийт 18.5 сая төгрөгөөр давж биелсэн бөгөөд Батсүмбэр, Баяндэлгэр, Мөнгөнморьт сумууд төлбөрийн орлогыг илүү төвлөрүүлсэн байна.

2015 онд ойгоос мод ашигласаны төлбөрийн орлого 87.9 сая төгрөгөөр буюу 37.5 хувиар тасарсан байна.

Батсүмбэр, Мөнгөнморьт, Жаргалант сумдын орлогын төлөвлөгөө өндөр дүнгээр тасарсан байгаа нь 2015 онд “Цэвэр ой” хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нөхөрлөлүүдэд сургалт зохион байгуулж, аттестатчилал хийсний дараагаар тухайн сумдад талбай тусгаарлалтын ажил хийгдэж ойн нөхөрлөлүүдтэй гэрээ хийх ажлыг зохион байгуулах, сумдын Засаг даргын захирамжид тусгасан Ой нээх, хаах хугацааг уялдуулаагүйтэй холбоотой байна.

Эдгээр сумдад ойгоос арчилгаа цэвэрлэгээний огтлол хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагууд байдаг ба бэлтгэсэн модны экологи эдийн засгийн үнэлгээнд үндэслэн

хэрэглээний болон түлээний модоор ялгаж үнэ тогтоож төлбөр хураамжийг ногдуулдаг байна.

Мөн мод бэлтгэхээр тусгаарлалт хийсэн талбайгаас гарах модны хэмжээг нарийвчлан тогтооход хүндрэлтэй тул арчилгаа цэвэрлэгээний явцад талбайгаас гарах модны хэмжээ нэмэгдэх тохиолдол байдаг байна. Энэ нь ойгоос мод ашигласаны төлбөрийн орлого нэмэгдэх нэг нөхцөл болдог байна. 2015 онд ойгоос мод ашигласаны орлого 87.9 сая төгрөгөөр тасарсан байна.

Ойн нөөц бүхий сумдын ой мод ашигласаны төлбөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг он тус бүрээр харуулав.

/ сая төгрөгөөр/

№	Сумдын нэрс	2014 он		2015 он		2016 он	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл 7 сараар
	Алтанбулаг	0.3	0.3	0.3	0.4	0.3	
2	Батсүмбэр	47.4	54.1	68.8	37.8	6.8	18.7
3	Баяндэлгэр	6.1	10.6	7.2	5.5	7.2	4.7
4	Баянцогт	6.1	6.2	6.2	4.3	5	1.2
5	Баянчандмань	2.9	4.7	5.2	2.3	4.7	0.7
6	Борнуур	10	10	12.7	9.9	10	5.6
7	Жаргалант	17.9	15.5	27.1	8.7	17	4.9
8	Заамар	0.2	0.4	0.8	0.3	0.3	
9	Мөнгөнморьт	59.2	66.7	75.3	65.7	75	25
10	Сүмбэр	0.6	0.3	1.2	0.3	0.7	0.1
11	Угтаал	4.2	4.5	5	2.9	4.5	1.5
12	Цээл	2.2	4	4.2	3.2	4.3	1.9
13	Эрдэнэ	19.2	17.7	20.2	9.7	16	8.7
14	Эрдэнэсант		0.1	0.3	0.1		
	Нийт	176.6	195.1	234.6	146.7	151.8	73.2

Ан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн орлого нь 2014 онд төлөвлөгөөний биелэлт 115.7 сая төгрөг буюу төлөвлөсөн хэмжээнээс 4.7 дахин давж биелсэн байна. Үүнээс Алтанбулаг суманд 17.4 сая төгрөг, Баян-Өнжүүл суманд 47.9 сая төгрөг, Өндөрширээт суманд 31.4 сая төгрөгөөр давж биелсэн ба Лүн суманд төлөвлөгөөгөөр ногдуулалт хийгээгүй боловч 20.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

2015 онд төлөвлөгөөний биелэлт 197.4 сая төгрөг буюу төлөвлөсөн хэмжээнээс 4.5 дахин давж биелсэн байна. Үүнээс Алтанбулаг суманд 39.7 сая төгрөг, Баян-Өнжүүл суманд 34.7 сая төгрөг, Өндөрширээт суманд 23.8 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна. Энэ онд ан агнах зөвшөөрлийн хураамжийн орлого төлөвлөөгүй боловч Баянцагаан суманд 58.4 сая төгрөг, Бүрэн суманд 11.0 сая төгрөг, Лүн суманд 40.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Баянцагаан суманд шонхор шувуу бариулсаны төлбөр гэж 58.4 сая төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлсэн ба энэ тухай БОНХАЖ-ын сайдын тушаал шийдвэр, тоо толгойг баталсан хуваарь байхгүй байна.

БОНХ-ийн сайдын 2014 оны 12-р сарын 04-ны өдрийн А-420 дугаар тушаалаар 2015 онд тусгай зориулалтаар амьтан агнах хуваарийг батласан боловч 2015 оны 5-р сарын 26-ны өдрийн БОНХАЖ-ын сайдын А-214 дугаар тушаалаар тусгай зориулалтаар 2015 онд

агнах, барих амьтаны тоо хэмжээг агнуурын бүс нутагт нэмэлтээр хуваарилсан нь энэ төрлийн орлого давж биелэхэд нөлөөлсөн байна.

2016 оны эхний 7 сарын байдлаар тухайн орлогыг төвлөрүүлэх байдал 0.4 хувийн биелэлттэй ба энэ нь ан агнах үйл ажиллагаа нь улирлын чанартай явагддагтай холбоотой байна.

Ан агнуурын зөвшөөрлын орлогын төлөвлөгөөний биелэлтийг сумдаар онуудаар харуулав.

/сая

төгрөгөөр/

№	Сумдын нэрс	2014 он		2015 он		2016 он	
		төлөвлөгө ө	гүйцэтгэ л	төлөвлөгө ө	гүйцэтгэ л	төлөвлөгө ө	гүйцэтгэ л
1	Алтанбулаг	8.8	26.2	10.8	40.5	29.7	
2	Батсүмбэр	0.8		0.8	0.2	0.6	
3	Баяндэлгэр	0.2		0.2		0.2	
4	Баян-Өнжүүл	10.8	58.7	27.2	61.9	29.7	
5	Баянцагаан				58.4		
6	Бүрэн				11.0	14.9	
7	Лүн		20.6		40.0	29.7	
8	Мөнгөнморьт	1.1	1.3	0.8	1.4	0.8	
9	Өндөрширээт	8.8	39.4	16.2	40.0	25.6	5.3
	Нийт	30.5	146.2	56.0	253.4	131.2	5.3

Ус ашигласаны төлбөрийн орлого 2014 онд ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлого 4.0 сая төгрөгөөр тасарсан бол үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны төлбөр 626.6 сая төгрөгөөр давж биелсэн байна. Үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг Заамар суманд 531.5 сая төгрөгөөр, Жаргалант суманд 7.0 сая төгрөгөөр, Сэргэлэн суманд 91.9 сая төгрөгөөр төлөвлөсөн хэмжээнээс илүү төвлөрүүлсэн байгаа нь тухайн сумдад үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компаниудын үйл ажиллагаанаас хамаарсан байна.

2015 онд мөн ахуйн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлого 18.9 сая төгрөгөөр тасарч, үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлого 105.3 сая төгрөгөөр давж биелэсэн байна.

Үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогын төлөвлөгөө Баян суманд 94.7 сая төгрөгөөр, Алтанбулаг суманд 10.0 сая төгрөгөөр Жаргалант суманд 8.4 сая төгрөгөөр давж биелэсэн бол Заамар суманд 11.0 сая төгрөгөөр, Эрдэнэ суманд 11.0 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Ус ашигласаны төлбөрийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сумдаар, онуудаар харуулав.

/сая төгрөгөөр/

№	Сумдын нэрс	2014 он				2015 он				2016 он			
		Ахуйн ус		Үйлдвэрлэлийн ус		Ахуйн ус		Үйлдвэрлэлийн ус		Ахуйн ус		Үйлдвэрлэлийн ус	
		төлө в	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц
1	Алтанбулаг	1.9	0.9	3.4	1.7	1.6	1.6	15.0	25.0	0.6		9.0	
2	Аргалант			2.5	0.7				1.5			1.8	1.3
3	Архуст	0.2	0.2		0.2	0.2	0.2	0.10	0.6	0.2	0.2	0.4	0.5
4	Батсүмбэр		0.09	2.0	2.6			2.5	1.4			2.8	0.1
5	Баян		1.1	31.3	31.0	1.0	0.4	31.0	125.7			16.9	36.9

6	Баяндэлгэр	0.2	0.3	0.2	6.9	0.2	0.2	0.7	0.6	0.2		0.7	
7	Баянжаргалан			11.9	5.9	0.5	0.5	12.0					
8	Баян-өнжүүл			0.5	0.1			0.5	1.0			1.7	0.4
9	Баянцагаан	1.2	0.1			0.8	0.8		1.0	0.3	0.2	0.9	
10	Баянцогт	0.3	0.3	1.9	1.9	0.3	0.3	1.8	1.0	0.3	0.1	1.2	0.6
11	Баянчандмань			17.6	23.8			21.5	24.7			27.2	0.2
12	Борнуур		0.1	9.3	6.9	0.1	3.7	2.2	4.8		0.1		0.7
13	Бүрэн			1.2			0.4	2.5	2.2	0.3		2.9	
14	Дэлгэрхаан				4.4	17.8			5.9				1.5
15	Жаргалант	8.6	1.9	80.4	87.4		0.4	85.0	93.4			91.8	30.0
16	Заамар	9.7	2.1	861.0	1392.5	3.5		1021.9	1010.5			888.9	362.4
17	Зуунмод	0.4	4.6	24.5	5.5	0.7	3.3			0.3	0.1		2.1
18	Лүн		0.4	1.0			0.8	0.8			0.7		
19	Мөнгөнморьт	0.4			1.4	0.5			0.9			0.9	0.5
20	Сүмбэр	0.2	0.7			0.7	2.4					0.3	0.3
21	Сэргэлэн		2.9	262.1	354.0		0.7	290.2	289.5			296.1	74.2
22	Цээл			9.8				8.3				6.3	
23	Угтаал-Цайдам			3.8				50.0	1.1	15.5			
24	Эрдэнэ	36.2	41.5	27.8	57.7	49.7	42.8	11.0			25.6	34.2	
25	Эрдэнэсант					0.1	0.1		3.0				
	Нийт	61.3	57.3	1352.1	1978.7	77.7	58.8	1557.1	1662.4	17.9	26.8	1389.3	511.8

Ургамал ашигласаны төлбөрийн орлогын биелэлт 2014 онд 155.8 сая төгрөгөөр давж биелсэн ба энэ нь Мөнгөнморьт суманд хуш модны самар их ургасантай холбоотойгоор тухайн орлого төлөвлөсөн хэмжээнээс илүү төвлөрүүлсэн байна. БОНХАЖ-ын сайдын 2015 оны 9-р сарын 18-ны өдрийн А/338 тоот тушаалаар үйлдвэрлэлийн зориулалтаар хуш модны самар түүж бэлтгэх зөвшөөрлийг Батсүмбэр, Мөнгөнморьт сумдад өгсөн ба төлбөр хураамжийн орлогыг Мөнгөнморьт сум төлөвлөсөн хэмжээнээс 158.2 сая төгрөгөөр давуулж төвлөрүүлсэн байна.

2015 онд Батсүмбэр суманд хуш модны самрын төлбөрөөс 80.0 сая төгрөгийн орлого төвлөрсөн боловч тухайн орлогыг нэр зааж ангилагдаагүй орлогын төрөлд оруулан орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Ургамал ашигласаны төлбөрийн орлогын биелэлтийг сумдаар, онуудаар харуулав.
/сая төгрөгөөр/

№	Сумдын нэрс	2014 он		2015 он		2016 он	
		төлөвлөгө ө	гүйцэтгэ л	төлөвлөг өө	гүйцэтгэ л	төлөвлөг өө	гүйцэтгэл
1	Алтанбулаг		0.1		0.1		
2	Батсүмбэр	0.2	0.2	0.3	0.2		
3	Жаргалант	0.8	9.1	2.0	0.5	1.0	
4	Мөнгөнморьт	35.3	182.7	35.2	193.4	5.0	
5	Эрдэнэ			1.1	0.5		
	Нийт	36.3	192.1	38.6	194.7	6.0	

Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлогыг төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрүүлсэн ба зарим суманд ан агнах зөвшөөрлийн хураамжийн орлого төлөвлөөгүй байхад орлого төвлөрүүлсэн байна.

Асуудал 3 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хууль тогтоомжийн дагуу төлөвлөгдсөн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулжээ.

Аудитын зорилт 3 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуваарилсан хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулсан эсэх

3.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь хэмжээг хуульд зааснаар мөрдсөн үү ?

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд нийт 58.8 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

“Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн 13.1-д заасан байгалийн нөөцийн төлбөрийн орлогоор санхүүжүүлж, хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөгөөг мөн хуулийн 13.4-т заасны дагуу аймгийн Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал батална гэж заасныг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулжээ.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан байгалийн ургамал, ан амьтан, ус, ойн нөөцийн төлбөрийн орлогоос байгаль хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь хэмжээг заасан байна.

Байгалийн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төрөл	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хувь, хэмжээний доод хязгаар /нийт орлогын дүнгээс хувиар/	
	2014 он	2015 он
1.Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого	30 хувь	15 хувь
2.Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	50 хувь	50 хувь
3.Газрын нөөцийн төлбөрийн орлого	30 хувь	15 хувь
4.Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	85 хувь	85 хувь
5.Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	55 хувь	35 хувь

Аймгийн ИТХ-аар байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогод газрын төлбөр болон үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогыг, сумын ИТХ-аар ой, ан агнуур, ус рашаан, байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогыг төлөвлөж, уг орлогоор аймаг, сумын байгаль хамгаалах санг бүрдүүлдэг бөгөөд энэ нь “Төсвийн тухай” хуулийн 23.6, 23.8, “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн 18.1 гэсэн заалтуудаар зохицуулагддаг байна.

Байгаль хамгаалах сангийн орлогыг 2014 онд 58.8 сая төгрөгөөр, 2015 онд 300.4 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэлээс байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн дүнг хүснэгтээр харуулбал:

/сая:төг/

№	Сумын нэр	2014 он				2015 он			
		гүйцэтгэл	БХС-д төвлөрүүлэх	төвлөрүүлсэн	Зөрүү	гүйцэтгэл	БХ арга хэмжээнд хуваарилах	Хуваарилсан	Зөрүү
1	Алтанбулаг	27.6	13.9	-	13.9	42.6	21.2	4.5	16.7
2	Аргалант	-	-	-	-	-	-	-	-
3	Архуст	0.2	0.1	1.7	- 1.6	0.2	0.1	0.6	0.1
4	Батсүмбэр	54.4	46.1	47.2	- 1.2	38.2	32.3	-	32.3
5	Баян	1.1	0.6	-	0.6	0.4	0.1	-	0.1
6	Баяндэлгэр	10.9	9.2	7.5	1.7	5.7	4.7	1.1	4.7
7	Баянжаргалан	-	-	1.9	-1.9	0.5	0.2	-	0.2
8	Баян-Өнжүүл	58.7	29.4	8.3	21.0	62.0	31.0	1.7	31.0
9	Баянхангай	-	-	2.5	- 2.5	-	-	-	-
10	Баянцагаан	0.1	0.1	1.9	- 1.8	59.2	29.5	-	29.5
11	Баянцогт	6.6	5.5	6.8	-1.3	4.7	3.8	-	3.8
12	Баянчандмань	4.7	4.0	8.5	-4.5	2.3	2.0	0.4	2.0
13	Борнуур	10.1	8.6	14.7	- 6.1	13.4	9.6	-	9.6
14	Бүрэн	-	-	-	-	11.3	5.6	6.9	5.6
15	Дэлгэрхаан	-	-	1.2	- 1.2	-	-	-	-
16	Жаргалант	26.4	16.9	11.9	5.0	9.6	7.6	-	7.6
17	Заамар	2.5	1.5	4.7	- 3.2	0.3	0.3	-	0.3
18	Зуунмод	4.6	2.5	-	2.5	3.4	1.2	-	1.2
19	Лүн	21.1	10.6	7.2	3.4	40.9	20.3	4.0	20.3
20	Мөнгөнморьт	250.7	112.1	55.1	57.1	260.5	85.5	4.0	85.5
21	Өндөрширээт	39.4	19.7	25.7	-6.0	39.9	20.0	1.6	20.0
22	Сүмбэр	1.0	0.6	6.5	-5.9	2.7	1.1	0.5	1.1
23	Сэргэлэн	2.9	1.6	1.6	0.1	0.8	0.3	6.4	0.3
24	Угтаал	4.5	3.8	4.7	-0.8	3.0	2.5	0.9	2.5
25	Цээл	4.0	3.4	13.0	- 9.6	3.2	2.7	1.8	2.7
26	Эрдэнэ	59.2	37.9	34.8	3.0	53.0	23.3	-	23.3
27	Эрдэнэсант	0.1	0.1	2.0	-1.9	0.2	0.1	-	0.1
	нийт	590.8	328.1	269.3	58.8	658.0	304.9	34.4	300.4

Хүснэгтээс харахад байгаль хамгаалах сангийн орлогыг бүрдүүлэхдээ “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Мөн Батсүмбэр сум ойн дагалдах баялаг болох самрын 80.0 сая төгрөгийн орлогыг байгалийн баялаг ашигласны төлбөр гэж мэдээлэлгүй нэр зааж ангилагдаагүй орлогоор мэдээлж байгаль хамгаалах санд 12.0 сая төгрөгийг төвлөрүүлээгүй, Аргалант сум БХС-д байгалийн ургамал ашигласны төлбөр 10.0 сая төгрөг оруулсан боловч татварын орлогоор мэдээлээгүй байна.

3.2 Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.3-т заасан арга хэмжээнд зарцуулсан уу

Ойг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас ЗДТГ-ын урсгал зардалд зарцуулсан байна

Төв аймгийн нутаг дэвсгэрт Батсүмбэр сумын сум дундын ойн анги 16 сумын 2369.4 мянган га ойн сан, Мөнгөнморьт сумын сум дундын ойн анги 6 сумын 1118.8 мянган га ойн сан бүхий газар нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Ойн төлбөрийн орлогыг сумдаар задалж үзвэл

/сая төгрөгөөр/

№	Сумын нэр	2014 он				2015 он			
		гүйцэтгэл	БХС-д төвлөрөх	Төвлө рүүлсэн	Зөрүү	гүйцэтгэл	БХ арга хэмжээнд хуваарилах	Хуваарил сан	Зөрүү
1	Алтанбулаг	0.3	0.3	-	0.3	0.4	0.3	-	0.3
2	Батсүмбэр	54.1	46.0	47.1	46.0	37.8	32.2	-	32.2
3	Баяндэлгэр	10.6	9.0	7.5	9.0	5.5	4.7	0.0	4.7
4	Баянцогт	6.3	5.3	6.8	5.3	4.3	3.7	-	3.7
5	Баянчандмань	4.7	4.0	8.2	4.0	2.3	2.0	1.0	2.0
6	Борнуур	10.0	8.5	14.7	8.5	9.8	8.3	-	8.3
7	Дэлгэрхаан	-	-	1.2	-	-	-	-	-
8	Жаргалант	15.5	13.2	11.9	13.2	8.7	7.4	0.0	7.4
9	Заамар	0.4	0.3	4.7	0.3	0.3	0.3	-	0.3
10	Мөнгөнморьт	66.7	56.7	55.1	56.7	65.7	55.8	-	55.8
11	Сүмбэр	0.3	0.2	6.5	0.2	0.3	0.2	-	0.2
12	Угтаал	4.5	3.8	4.7	3.8	3.0	2.5	-	2.5
13	Цээл	4.0	3.4	10.2	3.4	3.2	2.7	-	2.7
14	Эрдэнэ	17.7	15.0	34.8	15.0	9.7	8.2	4.6	8.2
15	Эрдэнэсант	0.1	0.1	2.0	0.1	0.1	0.1	-	0.1
	нийт	195.14	165.87	215.35	165.87	151.04	128.39	5.64	128.39

Байгаль хамгаалах сангаас зарцуулсан зардлыг 2015 оноор авч үзвэл цалингийн зардалд 28.37 сая төгрөг, зориулалт бус зардал 5.8 сая төгрөг, түймэр унтраахад 0.5 сая төгрөг, шатахуунд 65.3 сая төгрөг, тохижилт үйлчилгээнд 20.7 сая төгрөг, нөхөн сэргээлтэд 14.5 сая төгрөг зарцуулсан байна. Хөрөнгө худалдан авахад 3.9 сая төгрөг, акт барагдуулахад 15.4 сая төгрөг, санхүүгийн программын шинчлэл хийлгэхэд 1.1 сая төгрөг, сумын өдөрлөг зохион байгуулахад 3.4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ыг зөрчиж байна.

3.3 Усны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.2-т заасан арга хэмжээнд зарцуулсан уу

Усны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг төслийн нэгжийн ажилчдын цалинд 54.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Аймгийн ИТХ-аар “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасны дагуу газрын төлбөрийн орлогын 15 хувийг, үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөрийн орлогын 35 хувийг, сумдын ИТХ-аар ой, ан агнуур, ус рашаан, байгалийн ургамал ашигласны төлбөрийн орлогын хуулинд заасан тодорхой хувиар төлөвлөж тус орлогоор аймгийн Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын эх үүсвэрийг бүрдүүлж байна.

Усны төлбөрөөс аймгийн байгаль хамгаалах санд 2014 онд 911.4 сая төгрөг, 2015 онд 11.8 сая төгрөг тус тус төвлөрсөн байна.

2014 онд Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 932.2 сая төгрөг батлагдсаныг БОАЖГ-аар дамжуулан зарцуулсан байна. Зардлын зориулалтыг тодруулбал:

- Усыг зүй зохистой ашиглах, хамгаалах 3 ажилд 237.9 сая төгрөг
- Цөлжилтийг сааруулах 3 ажилд 70.0 сая төгрөг
- Ойн нөхөн сэргээлт, ойжуулалтын арчилгааны 6 ажилд 89.3 сая төгрөг
- Уул уурхайн 2 ажилд 28.0 сая төгрөг
- Хог хаягдлын менежментийг сайжруулах 2 ажилд 66.5 сая төгрөг
- Ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, иргэд, хүүхэд залуусын экологийн боловсролыг дээшлүүлэх 3 ажилд 24.3 сая төгрөг
- Материал, техникийн 3 зардалд 114.0 сая төгрөг
- Байгаль орчныг хамгаалах бусад 4 ажилд 302.2 сая төгрөг батлагдаж, зарцуулагдсан байна.

Дээрх батлагдсан зардлуудаас материал, техникийн 114.0 сая төгрөгийн зардлаас бусад нь байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулагдсан байна.

БОАЖГ-аар дамжуулан санхүүжүүлэх талаар гарсан аймгийн ИТХ-ын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж шийдвэр байхгүй байна.

2015 онд аймгийн Төрийн сан банкин дахь байгаль хамгаалах сангийн 140051408 тоот данс, БОАЖГ-ын 14001300181701 гэсэн тоот дансуудаар байгаль хамгаалах сангийн гүйлгээ хийгджээ. 140051408 тоот данс нь 2015 оны эхэнд 72.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан бөгөөд 11.8 сая төгрөгийн орлого орж, 76.1 сая төгрөгийн зардал гарсан байна.

Уг харилцах данснаас 54.9 сая төгрөгийн цалингийн зардал, шатахуун сэлбэг хэрэгсэлд 10.8 сая төгрөг, хөрөнгө оруулалтын санхүүжилтэд 10.1 сая төгрөг зарцуулагджээ. 2015 оны 4 сарын а/165 тоот аймгийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” захирамжаар байгаль хамгаалах сангаас хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр худалдан авсан 295.0 сая төгрөгийн 3 техник, хэрэгслийг “Бүтээн байгуулалт төслийн нэгж”-д шилжүүлэх шийдвэр гарч актаар хүлээлгэн өгсөн байна.

Уг төслийн нэгжийг 2014 оны 4 сард аймгийн Засаг даргын 10 тоот захирамжаар дарга, төслийн ажилтан гэсэн орон тоотойгоор төсвийн хэмнэлт, үлдэгдлээс болон шинэ сум төслийн техник хяналтын зардлаас санхүүжүүлэхээр шийдвэр гарсан байна. Гэвч 2015 оны 1 сараас эхлэн төслийн 2 ажилтан, 3 жолоочийн цалин болон бусад зардалд нийт 54.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

3.4 Байгалийн ургамал, ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3.1, 3.4-т заасан арга хэмжээнд зарцуулсан уу

Ан агнуурын орлогыг зориулалтын дагуу менежментийн төлөвлөгөө, судалгааны зардалд зарцуулсан байна.

Төв аймгийн агнуурын менежментийн төлөвлөгөөнд агнуурын бүс нутгийг 5 суманд 9 агнуурын бүс байхаар төлөвлөсөн байна. Агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлого 2014 онд 146.2 сая төгрөг, 2015 онд 253.4 сая төгрөг орон нутгийн татварын орлогын дансанд төвлөрчээ.

Орлогыг сумдаар задалж харвал

№	Сумын нэр	2014 он				2015 он			
		гүйцэтгэл	БХС-д төвлөрөх	Төвлө рүүлсэн	Зөрүү	гүйцэтгэл	БХС-д төвлөрөх	Төвлө рүүлсэн	Зөрүү
1	Алтанбулаг	26.2	13.1	-	13.1	40.5	20.3	-	20.3
2	Батсүмбэр	-	-	-	-	0.2	0.1	-	0.1
3	Баян-Өнжүүл	58.7	29.4	-	29.4	62.0	31.0	-	31.0
4	Баянцагаан	-	-	-	-	58.4	29.2	-	29.2
5	Бүрэн	-	-	-	-	10.9	5.5	-	5.5
6	Лүн	20.6	10.3	6.5	3.8	40.0	20.0	4.0	20.0
7	Мөнгөнморьт	1.3	0.6	-	0.6	1.4	0.7	-	0.7
8	Өндөрширээт	39.4	19.7	25.7	-6.0	39.9	20.0	-	20.0
9	Сэргэлэн	-	-	1.6	-1.6	-	-	0.6	-0.6
	нийт	146.24	73.12	33.83	39.29	253.43	126.72	10.41	126.12

2014 онд 8 угалз, 11 буга агнуулж 146.2 сая төгрөг, 2015 онд 11 угалз, 10 буга агнуулж 253.4 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт оруулсан байна.

Ан агнуурын бүсийн сумдаа Лүн сум халиун буга үржүүлэхээр Засаг дарга иргэн Л.Болдбаатартай гэрээ байгуулж менежментийн төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлж ажилласан байна. Баян-Өнжүүл сум орон нутагтаа тарвага нутагшуулахад 5.0 сая төгрөг, Бүрэн, Өндөрширээт сумд ан гануурын менежментийн төлөвлөгөө хийлгэхэд 10.3 сая төгрөг, судалгаа хийхэд 11.8 сая төгрөг зарцуулсан байна.

Сэргэлэн сум 2015 онд шонхорын орлогыг орон нутгийн татварын орлогоор тайлагнаагүй байж БХС-д төвлөрүүлсэн байна. Лүн сум байгаль хамгаалах сангаас сумын өдөрлөгт 4.0 сая төгрөг зарцуулж санхүүгийн тайланд ЗДТГ-аас авах авлагаар тусгасан байна.

3.5 Байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлөх хөнгөлөх, болзол хувь хэмжээг орон нутгийн нөхцөл онцлог байдлыг харгалзан хуульд заасны дагуу зөв шийдвэрлэсэн үү.

2014 онд ойгоос мод бэлтгэсэн иргэн, аж ахуйн нэгжийн төлбөрийг хөнгөлөөгүй байна. 2015 онд ойгоос цэвэрлэгээний аргаар түлээний мод бэлтгэсэн иргэдийн төлбөрийг хус, улиас, улиангар модонд 20 хувь, шинэс, нарс модонд 30 хувиар тооцон хөнгөлсөн байна. Энэ нь “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийн 16.2, 21.2-т заасныг үндэслэн Засгийн газрын 2014 оны 307 дугаар тогтоолоор батлагдсан 3 дугаар хавсралтанд заасан хувь хэмжээнд нийцэж байна.

Асуудал 4

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд дотоод хяналтын ажил хийгдээгүй байна.

Аудитын зорилт 4 Байгаль хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хийх дотоод хяналт хуульд заасны дагуу хэрэгжүүлсэн эсэх

4.1 Хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн үү?

Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Ойн тухай хууль, Амьтны тухай хууль, Ургамлын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиуд, Засгийн газрын 43 дугаар тогтоолоор батлагдсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах, төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журамын дагуу хяналтын тогтолцоог хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч дараах заалтуудыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Засгийн газрын 43 дугаар тогтоолын 4.1 “сум дүүргийн засаг дарга нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийн төлөвлөгөө, зарцуулалтын тайланг сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн Байгаль орчныг асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ”
- Засгийн газрын 43 дугаар тогтоолын 4.2 “аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага нь энэхүү журмын 4.1-д заасан төлөвлөгөө, тайланг нэгтгэн боловсруулж жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор байгаль орчныг асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ”
- Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолын 4.3-т “Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн байгалийн нөхөн сэргээгдэх нөөцийг хамгаалах, зохистой ашиглах нөхөн сэргээх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад жил бүр санхүүгийн дотоод аудит, хяналт-шинжилгээ хийнэ” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

4.2 Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих дотоод нэгжээс хяналтыг хэрэгжүүлсэн үү?

Монгол улсын ерөнхийлөгчийн 2014 оны 48 дугаар зарлиг, БОНХСайдын 2014, 2015 онуудад баталсан “Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх” ажлыг эрчимжүүлэх аяны удирдамж, “Хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 тоот албан даалгаварын дагуу аймгийн хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан батлуулж сумдад хүргүүлэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Ойн тухай хуулийн хэрэгжилтийг БОНХАЖЯам, МХЕГазар, ЦЕГазар, МБОИЗ-ийн хамтарсан шалгалтыг Мөнгөнморьт, Батсүмбэр сумдын сум дундын ойн ангиудад хийсэн байна. Шалгалтаар мод бэлтгэдэг аж ахуй нэгжүүд хамрагдаж ойн хуулийн хэрэгжилт хангалттай дүгнэгдсэн байна.

“Ойн тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор БОАЖГ, МХГ, ЦГ-тай бүрэлдэхүүнтэйгээр сумдын БОХ-ын улсын байцаагч, байгаль хамгаалагч нар хэсгийн төлөөлөгч нартай хамтран 2 удаагийн хийсэн шалгалтаар нийт 341 иргэн, 35 байгууллага аж ахуй нэгжүүдийг хамруулан 59 зөрчил илрүүлсэн байна. Зөрчлийг арилгуулахаар 38

заалт бүхий 18 албан шаардлага өгч, хууль бусаар бэлтгэсэн 58 шоо метр мод хурааж, 101 тээврийн хэрэгсэл шалгалтанд хамрагдсан байна. Хяналт шалгалтын явцад 59 зөрчил илэрч 52 зөрчлийг арилгуулж, 8 дүгнэлт, 2 акт үйлдэн 58м3 мод хурааж, 343кг хуш модны самар устгаж, 18 зөрчилд 47.1 сая төгрөгийн торгууль, нөхөн төлбөр ноогдуулж 12 зөрчлийг хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.

Аймгийн Аудитын газраас Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал болон Байгаль хамгаалах сангийн 2015 оны санхүүгийн тайланд санхүүгийн аудит, 2014 он, 2015 оны эхний хагас жилийн зарцуулалтанд гүйцэтгэлийн аудитыг тус тус хийсэнээс өөр хяналт хийгдээгүй байна.

Ойн санд хяналт тавих эрхий бүхий байгаль хамгаалагч нь мод бэлтгэх эрхийн бичгийг бичиж байгаа нь бэлтгэсэн модны хэмжээнд тавих хяналт алдагдах нөхцлийг бүрдүүлж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтийг бодитой дүгнэхгүй байна
2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл арга, хэмжээний зардлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна
3. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хууль тогтоомжийн дагуу төлөвлөгдсөн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулжээ.
4. Байгалийн нөөц ашигласаны төлбөрийн орлогыг төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрүүлсэн байна.
5. Зарим суманд шонхор шувуу бариулсаны төлбөр гэж орон нутгийн орлогод төвлөрүүлсэн ба энэ тухай БОНХАЖ-ын сайдын тушаал шийдвэр, тоо толгойг баталсан хуваарь байхгүй байна.
6. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хууль тогтоомжийн дагуу төлбөрийн орлогыг дутуу төвлөрүүлж, зориулалт бусаар зарцуулжээ.
7. Байгалийн орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтанд дотоод хяналт хийгдээгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн БОАЖГ-ын дарга Б.Болдбаяр нарт зөвлөх нь:

1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтийг бодитой дүгнэж байх.
2. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төсвийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасны дагуу бүрэн төлөвлөж, хуваарилах.
3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд орсон өөрчлөлт, Засгийн газрын 2014 оны 43 тогтоолоор шинэчилэн батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 4.1, 4.2, 4.3 дахь заалтуудыг мөрдөж ажиллах
4. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар батлагдсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахад анхаарч ажиллах

ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л. ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
ШИНЖЭЭЧ

Ц.БАЗАРСАД
Ж.БЯМБАЦОГТ
Ц.ХИШИГЖАРГАЛ

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал



**ТӨВ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70273290, Факс: 70272457
E-mail: boajg_tuv@yahoo.com Цахим хуудас: baigali.to.gov.mn

2016.10.10 № 07/466

танай _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Монгол усын Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүн /Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааны үр дүн/, байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцлаа.

Зарим тайлбарыг өгч, тайлангын үр дүнд гарсан холбогдох зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах болно.

ДАРГА



Б.БОЛДБАЯР



МОНГОЛ УЛС
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/22

Зуунмод

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 121 тоот тушаалын 11 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 138 тоот тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын нийтлэг эрх, үүргийн дүрэм" –ийн 2.2.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2016 оны А/95-р тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 7.1 дэх заалтуудыг үндэслэн **ТУШААХ нь:**

1. Улсын Их Хурлын Төсвийн Байнгийн хорооны 2016 оны 01 дүгээр тогтоол, Үндэсний аудитын газрын 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу "Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилт" сэдэвт нийцлийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийг баталгаажуулсугай.

2. Нийцлийн аудитаар өгсөн албан шаардлагыг 68.0 сая төгрөгөөр баталсугай.

3. Нийцлийн аудитаар өгөгдсөн дүгнэлт, зөвлөмж, албан шаардлагын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор /Ц.Базарсад, аудитор Ж.Бямбацогт, шинжээч Ц.Хишигжаргал/- нарт даалгасугай.

4. Аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу тодорхой арга хэмжээ авч ажиллаж, илэрсэн алдаа зөрчлийг арилган, цаашид давтан гаргахгүй байх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжилтийг 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймгийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Б.Болдбаяр, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ю.Бямбацогт/- нарт зөвлөсүгэй.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ЖАРГАЛСАЙХАН